



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/327

Мандалговь

Замын зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.5, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Б.Саруулцэцэгийг Сингапур улсын Нанянийн политехникийн их сургуульд болох "Монгол улсын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх нь" сэдэвт 14 хоногийн хугацаатай сургалтанд хамрагдахад замын зардлын дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Б.Саруулцэцэгийн замын зардлын дэмжлэг болох 1500000 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

0200896